

ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН ТОХИЖИЛТ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хатанбулаг сумын 5 дугаар багт хийгдэх тохижилтын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **2 526 696 /Хоёр сая таван зуун хорин зургаан мянга** / төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 3%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

1. Спорт цогцолборын гадна фасадны ажил

Барилгын гадна фасадны шавардлагын гадаргуу тэгш, цууралтгүй байх ёстой. Цонх хаалганы амалгааны хөндийрч муудсан шавардлагыг бүрэн сайн буулгаж 1:2 цементэн зуурмагаар чанартай сайн шавардаж тэгшилгээ өнгөлгөөний ажлыг гүйцэтгэнэ.

Гадна фасадны өнгө сэргээх ажлыг гүйцэтгэхдээ барилгын гадна фасадыг хусах шаардлагатай гадаргууд хусалт хийж хөрсжүүлэлт хийн сайн чанарын эмульсан будгаар БНБД-н дагуу будалт хийнэ.

Барилгын гадна хаалганд үсгэн хаягыг тогтооно.

2. Грашийн байранд нүхэн жорлон барих ажил

MNS 5924:2015 стандартын дагуу хоёр хүний хагас нэвчилтэй нүхэн жорлонг хийж гүйцэтгэнэ.

- Рамыг квадрат төмрөөр гагнаж зангидаж хийх
- Битүүмжлэл сайтай байх ёстой тул хана таазыг сэндвич хавтангаар хийнэ
- Бүхээгийн гадна болон дотор талд түгжээтэй байна.
- Бүхээгийн хаалганы дээд талд 400мм урттай 200мм өргөн ялаа шавьж орхоос хамгаалсан тор бүхий цонхтой байна.
- Шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байх/ нарны гэрлээр цэнэглэгддэг гэрэлтүүлэг/
- Шалыг халтирдаггүй материалаар хийх

- Агааржуулалтыг хийж ердийн дефлектор угсрах
- Нүхний ханыг хагас нэвчих, нуралтаас хамгаалах зорилгоор модоор доторлох

3. Бохир усны нүх хийх

Төв бохирын шугамын худгаас 5м зайд зөөврийн бохир ус асгах зориулалтын 2 ширхэг худгыг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

- Зөөврийн бохир усыг /угаадас/ асгах зориулалттай байна
- Бохирын худгийг бөглөрхөөс сэргийлсэн худгийн таганд саараалжин тор байрлуулна.
- Ф200мм трубагаар хөлдөхөөс сэргийлж дулаалж хийж гүйцэтгэнэ.
- Бохирын худгийг стандартын дагуу хийнэ.

4. Бусад ажил

ЗДТГ-ын гадна хаалганд гэрэлтдэг үсгэн хаяг хийж гүйцэтгэнэ.

Цахилгаан монтажийн угсралтын ажлыг гүйцэтгэх үед БНБД 3.05.06-90-г мөрдлөг болгоно. Заагдсан байрлалуудад овоорсон элсийг механизмаар түрж талбайг тэгшлэх, үерийн усаар эвдэрсэн зам талбайг тэгшлэх

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Гадна фасадны ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.